

**“ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН”ОНӨААТҮГ-ЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАН**



2024 оны 12 дугаар сарын 11

Дархан-Уул аймаг

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй:

Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлал, Байгууллагын дотоод хяналтын зөвлөлийн журмыг удирдлага болгов.

Дараах төлөвлөгөө, дүрэмд тусгагдсан үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 5 бодлогын тэргүүлэх зорилтод хамаарах нийт 54 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

- Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №2/07 тоот тогтоолоор батлагдсан “Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №11 тоот тогтоолоор батлагдсан “Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн №21 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм”

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

2. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн ч баримтжуулалт хангалтгүй байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө” боловсруулах загварын дагуу 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргаар батлуулсан байна.

Хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан байдал:

Арга хэмжээний нэр	Арга хэмжээний тоо		Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиглэл	Аймгийн Засаг Даргын 2021-2024 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиглэл
	2023	2024		
Зорилго 1. Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, хамгаалалт, тордолтыг байнга, тасралтгүй хийнэ.	18	23	1.2.3.2, 1.2.3.3	1.2.1.1, 1.2.3.4 1.5.4.4, 3.4.3.1 4.2.2.3
Зорилго 2. Хот доторх ногоон байгууламжийн үйлчилгээг өндөр бүтээмжтэйгээр хийж гүйцэтгэнэ.	10	11	4.2.2.2 4.2.2.3	2.7.2.13 4.2.2.4
Зорилго 3. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлнэ.	2	2	4.2.2.2	6.3.3
Зорилго 4. Хөдөлгөөнт тоглоомын төв, түрээсийн худалдаа үйлчилгээний орчныг сайжруулж, аюулгүй байдлыг хангахад идэвхи санаачлагатай ажиллана	10	10	5.3.1 4.5.1 3.4.1 4.1.4	3.1.3.1, 2.3.1.3 2.2.1.1, 1.2.3.2 1.2.1.2, 3.1.1.1 2.1.1.1, 1.5.2.3
Зорилго 5. Хуулийн хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавруудыг биелүүлж ажиллана.	6	9	5.3.1, 5.3.3 5.2.3, 3.5.1 5.1.1	3.1.3.1, 2.1.1.3 3.1.3.1, 3.1.2.1 1.2.1.3, 2.1.1 2.1.1.2
	46	54		

Байгууллагын дүрмээр баталсан үйл ажиллагааны үндсэн чиглэлд уялдуулсан зорилго, зорилтуудыг тодорхойлохын зэрэгцээ аймгийн Засаг даргын болон Дархан сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан “Хороолол доторх болон гудамж талбайн гэрэлтүүлгийг

нэмэгдүүлнэ”, “Цэвэр хот” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ, “Шарилжгүй Дархан”, Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин нөхцлийг бүрдүүлнэ, хот суурин газрын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ, иргэдэд бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлнэ, төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна, хог хаягдлын менежментийг сайжруулж, хог дахин боловсруулах технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг сайжруулна, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, Дархан сумын гэр хорооллын мал, туслах аж ахуйтай айл өрхүүдийг малтай багууд уруу шилжүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулж хотын ногоон байгууламжийг хамгаалах зэрэг арга, хэмжээтэй уялдуулан төлөвлөжээ.

Зорилго 1. Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, хамгаалалт, тордолтыг байнга, тасралтгүй хийнэ. 23 ажил төлөвлөснөөс 100% гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэлийн үеийн фото актууд байгаа ч түүнтэй холбоотой анхан шатны баримтууд, зардлын төсөв, хариуцсан менежерийн хийх үеийн үйл ажиллагааны тайлан, мэдээ хангалтгүй байна.

Зорилго 2. Хот доторх ногоон байгууламжийн үйлчилгээг өндөр бүтээмжтэйгээр хийж гүйцэтгэнэ. 11 ажил төлөвлөснөөс 100% гүйцэтгэсэн байна. Ногоон байгууламжинд нөхөн тарилт хийгдээгүй. Нийтийг хамарсан мод тарих үйл ажиллагааг хавар, намрын улиралд 2 удаа 17 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж, 470 хүнийг хамруулан 4569 мод тариалсан байна. Оны эхэнд төлөвлөгөө батлуулж, тайлагнадаггүй байна. Үйл ажиллагааны явцын тайлан баталгаажгаагүй нь адил байна.

Зорилго 3. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлнэ. “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн, Дархан-50 цогцолбор, Морин хуур цогцолбор, Залуус цогцолбор, Дүүжин гүүр, Бурхантай толгой, Эрдэнэтийн байгууламж, Сүрэнгийн гудамжныхаа хогийг өөрсдийн ангилан ялгах хогийн цэгтээ авчирч хуванцарыг нь ялгаж авдаг байна. Ингэснээр хогийн м3-ын хэмжээ багасахаас гадна байгаль экологитоо оруулж байгаа хувь нэмрийг үнэлэж, тооцоолох боломжгүй юм.

Зорилго 4. Хөдөлгөөнт тоглоомын төв, түрээсийн худалдаа үйлчилгээний орчныг сайжруулж, аюулгүй байдлыг хангахад идэвхи санаачлагатай ажиллана. Өмнөх онуудтай харьцуулахад хөдөлгөөнт тоглоомын орчинд тохижилтын ажил их хийгдсэн байна. Орлогоо нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилготой түрээслэгчидийн тоог нэмэгдүүлэн ажилласан байна.

Гэвч энэ нь бизнес эрхлэгч нарт өрсөлдөөн үүсэж байгаа мэт боловч эсрэгээрээ түрээслэгч талын орлого багасаж, 2025 оны түрээслэгчийн тоо буурах магадлалтай. Түрээслэгч нарт үйлчилгээ үзүүлэх байгууламжид нь стандарт тавихгүй байгаа нь байгууллагын өнгө үзэмж, үйлчилгээний соёлыг бууруулж харагдаж байна. Мөн ногоон байгууламжинд сөрөг нөлөөлөлтэй, эко байдал, цэцэрлэгт хүрээлэнгийн утгаа алдана гэж үзэж байна.

Тоглоомын орлого өмнөх оны гүйцэтгэлээс 164 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. 2024 оны Орлогын төлөвлөгөөгөө 75%-аар илүү биелүүлсэн байна. Энэ нь тоглоомын засвар үйлчилгээг тогтол сайн хийж 7 тоглоом бүрэн хүчин чадлаараа тасралтгүй ажилласантай холбоотой гэж үзлээ. Иймд цаашид засвар үйлчилгээ, сэлбэг хангамжийг сайн бэлтгэж ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Борлуулалтын орлого:

№	Утга	2023	2024	Зөрүү
1	Тоглоомын орлого	434,854,003	598,877,391	164,023,388
2	Түрээсийн орлого	66,020,000	129,235,000	63,215,000
3	Нийт орлого	596,272,733	743,413,759	147,141,026

Зорилго 5. Хуулийн хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавруудыг биелүүлж ажиллана. Хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, хэрэгжүүлж ажилласан байна.

Үнэлгээ:

Д/д	Бүлэг	Бүгд	Нэг	Хоёр	Гурав	Дөрөв	Тав
	Үнэлгээ						
1	Шалгуур үзүүлэлтийн тоо	55	23	11	2	10	9
2	Бүрэн хэрэгжсэн -100%	55	23	11	2	10	9
	Хэрэгжих шатанд-70%	0					
	Хэрэгжилт хангалтгүй-30%	0					
	Хэрэгжээгүй-0%	0					
Ерөнхий үнэлгээ		100%	100%	100%	100%	100%	100%

Дүгнэлт:

Байгууллагын дэргэд дэх дотоод хяналтын зөвлөл гүйцэтгэлийн тайлантай танилцан дараах дүгнэлтийг хийж байна.

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үр дүнтэй хийж гүйцэтгэсэн ч тайлагнал хангалтгүй, хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.
- Үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөж, хэмнэлттэй зарцуулсан байна.
- Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, иргэд чөлөөт цагаа өнгөрөөх, тав тухтай орчин бүрдүүлсэн үр дүнтэй бүтээн байгуулалтуудыг олноор хийж гүйцэтгэсэн байна.
- Байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга зүйн зөвлөгөөг дунд шатны менежерүүдэд өгч, арга хэмжээ бүрээр үнэлж, дүгнэж ур чадвар, урамшуулалтай холбох.

Зөвлөмж:

- Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг дунд шатны менежерүүдээс дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор авч байх.
- Дунд шатны менежерүүдээс ирсэн тасаг, хэсэг албадуудын төлөвлөгөөг ахлах менежер 01 дүгээр сарын 15-ны дотор нэгтгэж, баталгаажуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө төлөвлөх.

Танилцсан:

“Дархан Хотын Соёл Амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын
Дарга Л.Тамир

Хянасан:

Дотоод хяналтын зөвлөлийн дарга Г.Ариунаа

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:

Дотоод хяналтын зөвлөлийн гишүүд

С.Мөрөн
Ш.Гантулга
Ж.Батжаргал

Хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан боловсруулсан:

Дотоод хяналтын зөвлөлийн
нарийн бичиг

Ц.Батхишиг

**“ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН” ОНӨААТҮГ-ЫН
ДОТООД ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Дугаар:

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Дархан-Уул аймаг

Хуралд ирвэл зохих 5 гишүүнээс 5 гишүүн ирж 100%-ийн ирцтэйгээр 17 цаг 15 минутад “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн дэх “Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн” ОНӨААТҮГ-ын оффист эхлэв. Дотоод хяналтын зөвлөлийн дарга Г.Ариунаа ирц, хэлэлцэх асуудлыг танилцуулж, хурлыг даргалав.

Хуралд:

Агрономич

Г.Ариунаа

Архив, бичиг хэрэг

Ц.Батхишиг

ХАБАЭИ инженер

С.Мөрөн

Зохион байгуулагч

Ш.Гантулга

Цахилгаанчин

Ж.Батжаргал нар оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Дархан Хотын Соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд үнэлгээ өгөх.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Г.Ариунаа: За хэлэлцэх асуудлуудыг та бүгдийн урд хэвлээд тавьсан байгаа. Төлөвлөгөө, тайлан тус тусдаа хэвлэгдсэн байгаа.

Ц.Батхишиг: Бид нэг байгууллагад, нэг зорилгын төлөө ажилладаг ч, байгууллагын дотоод хяналтын зөвлөлийн журмын дагуу байгууллагын үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, дээд газрын тогтоол шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, аливаа эрсдлээс хамгаалах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх, ёс зүйн зөрчил, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд манай зөвлөлийн зорилго оршдог. Иймд бусад гишүүд төлөвлөгөө, тайлантай танилцан үнэлгээг үнэн бодитой өгөхийг хувийн зүгээс хүсэж байна.

С.Мөрөн: Төлөвлөгөө, тайлантай танилцлаа. Миний хамгийн сайн мэдэх ажил бол Хөдөлгөөнт тоглоом юм. 2022 онд байгуулагдсан цагаас хойш байгууллагын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангахаас гадна үргэлж тоглоом дээрээ байдаг. Гүйцэтгэлийн тайлангийн 1.1.5 дахь аргам хэмжээнд тусгагдсан тоглоомын орчины тохижилт өмнөх жилүүдийг бодвол хангалттай сайн хийгдсэн, сайхан, тухтай ч болсон. 1.2.3 дахь арга хэмжээнд тусгагдсан

мананжуулагчийн ажил бол нүдээ олсон. Хүүхдүүдээ тоглуулж байгаа аав, ээжүүд сэрүүхэн гээд сэтгэл ханамж их өндөртэй байгаа нь харагддаг. 1.2.4 унадаг дугуйны зогсоол хийгдсэнээр хүүхдүүд унадаг дугуйндаа санаа зовох зүйлгүй сэтгэл амар тоглох нөхцлийг бүрдүүлсэн. 1.2.12 Тоглоомын нээлт. Мичидмаа тоглоомын нээлтийн үйл ажиллагаанд их нөлөөлсөн. Бид ч их хүүхэд ирнэ гэдэг тооцоололтой хөдөлгөөнт тоглоомуудын аюулгүй ажиллагаа, бэлэн байдлыг маш сайн хангаж ажилласан. Манай байгууллагын хувьд жил бүр хийгддэг 2.2.1 Шарилж устгалын ажил. Шарилж ихтэй байхад үйлчлүүлэгчидийн тоо ч багасдаг. Бороо хуртай жил бол манайхан 3 байтугай шарилж устгал хийгддэг. Сургалтыг бол тоглоомын операторууд, түрээслэгч нар, нийт ажилчид гээд хангалттай зохион байгуулсан гэж бодож байна.

Ш.Гантулга: Хөдөлгөөнт тоглоом нээгдэхээс хаах хүртэл хугацаанд С.Мөрөн яалт ч үгүй өдөр шөнөгүй ажилладаг аа. С.Мөрөнгийн хэлсэн дүгнэлтүүдтэй санал нэг байна. Хөдөлгөөнт тоглоомын орчинд эзэнгүй байсан нохдыг устгуулахаар С.Мөрөн бид 2 НААҮГ-руу 4 удаа ярьж 2 удаагийн устгалаар нийт 32 нохойг устгаж, иргэдийг аюулаас хамгаалж ажилласан. Тайланд тусгагдсан нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт, цэвэрлэгээ, хамгаалалттай холбоотой ажилууд дээр бүгдтэй нь танилцлаа. Гүйцэтгэлийн тайлангийн загвартаа захирагдан ганц, хоёрхон зураг оруулсан байгаа ч бидний үйл ажиллагаа цаг агаарын хүнд нөхцөл, баяр ёслолын үе зэргийг үл хамааран өдөр, шөнөгүй ажилладаг. Үйл ажиллагааны үеийн зургийг ажил бүрээр хэвлэвэл мэлээн их болох байх. Би бол ММЦХ-ийн арчлалт, хамгаалалтын ажилчидыг зохион байгуулж, удирддаг хүний хувьд бид үнэхээр хангалттай ажилласан гэж бодож байна.

Ж.Батжаргал: Би 2024 оны хавар ажилд тус байгууллагад ажилд орсон. Дотоод хяналтын зөвлөлд тус байгууллагын цахилгаанчин багтдаг шүү гэж анх ажилд орж байхад хэлсэн. Өөрийн хэмжээнд хэрэндээ л хяналт тавьж, аль болох өөрийн ажлын байрандаа болон бусдыг ажлын байран дээрээ алдаа дутагдал бүү гаргаасай гэж хүсэж ажилладаг. Ажлын хувьд ярих зүйл байдаггүй ээ. Харин сүүлд орж ирээд мэдээгүй байж магад. Оны сүүлээр ч юмуу, эхэнд ч юмуу хэсэг бүр дээр ажлын төлөвлөгөө, тайлан авдаг уу? Би бол ажлын тайлан групп дээрээ өдөр, өдрийн ажлын зурагаа илгээгээд яваад байгаагаа тайлан гэж ойлгоод байдаг. Зөв үү? Буруу юу? Тус гүйцэтгэлийн тайланд гэрэлтүүлэгтэй холбоотой хийгдсэн бүх ажил орсон байна.

Ц.Батхишиг: За ёстой Ж.Батжаргал ахтай санал нэг байна. Бидний хийж байгаа ажил сайн, муу байгаа нь хүмүүсийн нүдэнд ил байгаа хэдий ч цаас болох, баримт үлдэх тал дээрээ дутмаг байгаад байгаа юм. Дээр Ш.Гантулга хэлсэнчлэн бидний ажлын зургийг хэвлүүлвэл хэдэн хуудас юм гарна гэдэг шиг энэ зурагаа хэсгийн ахлагч нар оны эхэнд төлөвлөгөө болгож, оны сүүлд тайланд тусгаж баталгаажуулж баймаар байна. Оны эхэнд бүх хэсгийн дарга нар жилийн төлөвлөгөөгөө батлуулан Ахлах менежертээ өгөөд, ахлах менежер нэгтгэж, түүнийгээ гүйцэтгэлийн тайландаа тусгаж баталгаажуулмаар байгаа юм.

Г.Ариунаа: Өө яг үнэн. Ц.Батхишигийн хэлсэнтэй санал нэг байна. Ер нь бүх хүмүүстэй санал нэг байна. Би хувьдаа тус байгууллагын ногоон байгууламжийг хариуцан ажилладаг. 2024 онд хийсэн ажлууд бүгд туссан байна. Миний хувьд гүйцэтгэл хангалттай гэж үзэж байна.

Ц.Батхишиг: Онцолж хэлэх хэд хэдэн ажлууд байна. Санхүүгийн тайлангийн гүйцэтгэлтэй, гүйцэтгэлийн тайланг уяж харахад хүртэл үр дүн тодорхой байгаа юм. Ганц нэг тоо дурьдвал борлуулалт 2023 оноос 164 сая төгрөгөөр давуулан биелүүлж, гүйцэтгэл 75%-аар давсан гүйцэтгэлтэй байна. 2023 онд хөдөлгөөнт тоглоомын эвдрэл, сэлбэг хэрэгслийн олдоц зэргээс шалтгаалан 7 тоглоомоос 5 нь ажиллаж байсан бол энэ алдаагаа давтахгүйн тулд 2024 оны тоглоомын засвар сайн хийж, сэлбэг эд ангийн бэлтгэлийг сайн бэлтгэсний үр дүнд 7 тоглоом бүгд ажилласан нь борлуулалтын орлогоос харагдана. Мөн жижиг дунд бизнесийг дэмжих аймаг, сумын бодлогын хүрээнд түрээслэгч нарын тоог нэмэгдүүлсэн нь борлуулалтад бас нөлөөлсөн байна.

Г.Ариунаа: За тэгвэл үнэлгээгээ өгөх үү? Санал хураах уу? Бид төлөвлөгөөнд тусгагдсан 5 бодлогын тэргүүлэх зорилтод хамаарах нийт 54 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөх юм байна. Бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатанд, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй гэж санал аа хураачих уу? Санал хураалтын дүн:

- | | |
|-------------------------|---------|
| 1. Бүрэн хэрэгжсэн | - 5 хүн |
| 2. Хэрэгжих шатанд | - 0 |
| 3. Хэрэгжилт хангалтгүй | - 0 |
| 4. Хэрэгжээгүй | - 0 |

Гүйцэтгэлийн тайлан бүрэн хэрэгжсэн дээр 100% санал өгөв,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Гүйцэтгэлийн тайланг – 100% бүрэн хэрэгжсэн үнэлгээ өгөв.

Хянасан:

Зөвлөлийн дарга:

Агрономич

Г.Ариунаа

Гишүүд:

ХАБЭАИнженер

С.Мөрөн

Зохион байгуулагч

Ш.Гантулга

Цахилгаанчин

Бичиг хэрэг, архивын эрхлэгч

Ж.Батжаргал

Ц.Батхишиг

Тэмдэглэлтэй танилцсан:

“Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн” ОНӨААТҮГ-ын

Дарга



Л.Тамир

Тэмдэглэл хөтөлсөн:

“Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн” ОНӨААТҮГ-ын

Бичиг хэрэг, архивын эрхлэгч

Ц.Батхишиг